



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,
<http://www.mmhi.gov.mn>

**МОНГОЛ ГАЗРЫН ТОС
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА**


2021.09.09 № 01/2195
танай _____-ны № _____-т

**Засгийн газрын хуралдааны
тэмдэглэл хүргүүлэх тухай**

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаа болон охин компаниудын өнөөгийн байдал, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд аудит хийсэн дүн, ажлын хэсгийн дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэл гаргасныг хавсралтаар хүргүүлж байна.

Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан хангаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг мэдэгдье.

Хавсралт 2 хуудастай.


Г.ЁНДОН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлд:

“ХХҮИ.2. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаа болон охин компаниудын өнөөгийн байдал, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд аудит хийсэн дүн, Ажлын хэсгийн дүгнэлтийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: ✓

1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий газрын тосоор тогтвортой тасралтгүй, найдвартай хангах судалгаа, тооцоог хийж, нөөц болон олборлолтыг өсгөх ажлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав;

2. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хүрээнд импортоор орж ирсэн бараа материалын үнийн судалгааг гаргаж, хөрөнгө оруулалтын зардал болон төслийн зардлыг цаашид нэмэгдүүлэхгүй байх талаар хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгав;

3. “Эрдэнэс Монгол” ХХК, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Хаянхярваа, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нарт үүрэг болгов: ✓

3.1. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компаниудын зардлыг бууруулах, зарим шаардлагагүй охин компаниудыг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах санал боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх, үйл ажиллагаа нь эхлээгүй, зогссон охин компаниудыг орлого олох хүртэл зардлыг нь бууруулах, орд газрын нөөц, эдийн засгийн үр ашгийг тооцож, үр ашигтай ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах саналаа танилцуулах;

3.2. Газрын тос боловсруулах үйлдвэрийн техник, технологийн чиглэлийн мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх асуудлыг судлан танилцуулах;

3.3. Стратегийн ач холбогдолтой компаниуд өөрийн эзэмшлийн албан ажлын байргүй, түрээсийн өндөр зардалтай байгааг анхаарч, үйл ажиллагааг тогтвортой явуулах зорилгоор албан ажлын байрны асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал боловсруулж танилцуулах;

3.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Шилэн дансны тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллах; ✓

3.5. Аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, давтан гаргахгүй байх, аудитын дүгнэлт, зөвлөмж болон шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх." гэжээ. ✓



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР